



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 10 дугаар сарын 12

Дугаар 4

Улаанбаатар хот

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН IV ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын IV хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 12.00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д *107* хувийн ирцтэй хуралдав.

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан хуралдааныг даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

Хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар болон аймаг, ниислэлийн Засаг дарга, онцгой комиссын бүрэлдэхүүн оролцлоо.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Ц.Болорчулуун*

2. Эрчим хүчний салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц

*Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Ерэн-Өлзий*

3. Цаг агаарын төлөв байдлын талаар

*Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулга*

4. Барилга, нийтийн аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын
яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа*

5. Нийслэлийн 2025-2026 өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, агаарын бохирдлыг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар

6. Бусад

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}-д заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1.1. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндрэх, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл тохиолдох үед хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, иргэдэд эрүүл мэндийн болон төрийн бусад үйлчилгээг шуурхай тасралтгүй хүргэх төлөвлөлтийг нарийвчлан гаргах, бэлэн байдлыг хангах арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

1.2. “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

1.3. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх, үүсэж болох эрсдэлийг тооцож аймаг, сумдын ирэх 2026 оны төсөвт шаардлагатай хөрөнгийг тусгах;

1.4. Өвөлжилт, хаваржилтыг даван туулахад шаардагдах бүх төрлийн нөөцийг орон нутгийн түвшинд бүрдүүлэх;

1.5. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор бүх шатны онцгой комиссын шуурхай штабыг байгуулж, идэвхжүүлж ажиллах;

1.6. Бүх шатанд сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж шийдвэрлэх, гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, алдаа, дутагдалд холбогдох хууль, журамд заасан хариуцлагыг тухай бүр тооцож ажиллах;

Хоёр. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Бат-Амгалан, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, Зам тээврийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Дэлгэрсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр нарт:

2.1. “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 56 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн өргөтгөсөн хуралдаан, Улсын онцгой комиссын 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 3 дугаар хуралдаанаас өгсөн үүрэг, түүний хэрэгжилт, өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөө, гарц, шийдлийг нэгтгэн Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулах;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

3.1. “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 56 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн өргөтгөсөн хуралдаан, Улсын онцгой комиссын 2, 3 дугаар хуралдаанаас өгсөн үүргийн хэрэгжилтийг заалт тус бүрээр гаргаж, тайланг Улсын онцгой комиссын Ажлын албанд 2025 оны 10 дугаар сарын 14-ний дотор ирүүлэх;

Дөрөв. Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

4.1. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх эрсдэлтэй аймаг, сумдад өвс, тэжээл, мал, мах худалдах, худалдан авах нэрийдлээр залилах гэмт хэргийн гаралт нэмэгддэг тул уг төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Тав. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэнд:

5.1. Томуу, томуу төст өвчний өвчлөл нэмэгдэж байгаатай холбогдуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой, үр дүнтэй, хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах, салбарын бэлэн байдлыг хангах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнг тухай бүр Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаанд танилцуулах,

5.2. Отроор өвөлжиж хаваржих болон алслагдсан бүс нутагт оршин суугаа малчид, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй, хөдөлгөөнт байдлаар тогтмол үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Зургаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр, Цаг уур орчны шинжилгээний газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулга, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Баасандамба, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал, Улсын онцгой комиссын гишүүн Г.Гэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

6.1. Холбогдох мэргэжлийн байгууллагуудаас гаргаж буй бэлчээрийн даац, ган, зудын эрсдэлийн үнэлгээ, цаг агаарын төлөв байдал болон бусад болзошгүй эрсдэлийн мэдээллийг иргэд олон нийтэд тогтмол шуурхай хүргэх;

6.2. Малчид, иргэд, нутгийн захиргааны байгууллагуудын дунд үл ойлголцол үүсэхээс урьдчилан сэргийлж отор нүүдлийн зохион байгуулалт, хяналтын талаар олон нийтэд тогтмол ойлголт мэдээлэл өгөх;

Долоо. Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн засаг дарга нарт:

7.1. Эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах түлш, нүүрсний нөөцийг шаардлагатай хэмжээнд бүрдүүлэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр тухай бүр хангаж ажиллах;

Найм. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдиннямд:

8.1. Газрын тосны бүтээгдэхүүн, шатахуун, шатах тослох материалын нийлүүлэлт, түгээлтийг тогтвортой байлгах, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд тухай бүр иргэд олон нийтийг мэдээллээр хангах;

Ес. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, дэслэгч генерал С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн болон бүх шатны Засаг дарга нарт:

9.1. Байгаль цаг уурын гаралтай аюулт гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай бие бүрэлдэхүүн, тэдгээрийн хувцас, хэрэглэл, багаж, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, тоо хэмжээ, хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

9.2. Цас их орох, зам даваа хаагдах, цаг агаарын аюулт гамшигт үзэгдэл болох зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед зам, давааг чөлөөлөх, айл өрхүүдэд хүнс, түлээ түлш, малын тэжээл хүргэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг аймаг, сумдын Онцгой комисстой хамтран зохион байгуулах, уг ажилд шаардлагатай хүн, техник хэрэгслийг тухай бүр дайчлан гаргаж орон нутгийн Онцгой комисст дэмжлэг үзүүлж ажиллах;

Арав. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Бат-Амгаланд:

10.1. Хүйтний улирал эхэлж байгаа тул барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн явуулж газар гэсгээх зорилгоор түүхий нүүрс, сайжруулсан шахмал түлш ил задгай түлэх зэрэг зөрчил гаргахгүй байхад анхаарч, хяналт тавьж ажиллах;

10.2. Хот нийтийн аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотой төлөвлөгөөт ажлуудыг хугацаанд нь дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих, салбарын хэмжээнд бэлэн байдлыг хангаж ажиллах;

Арван нэг. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатарт:

11.1. Монгол Улсын Засгийн газрын газрын 2020 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн хангах, мэргэжлийн байгууллагуудтай хамтран угаарын хийн

хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах, шаардлагатай мэдээ мэдээллийг тогтмол хүргэж ажиллах;

11.2. Нийслэлийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөт хугацаанд хийж гүйцэтгэх, бэлэн байдлыг хангах;

11.3. Агаарын бохирдол, түгжрэл бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний явц, үр дүн, цаашид хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, гарц шийдлийн талаар Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулах;

Арван хоёр. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр нарт:

12.1 Мал, махыг эдийн засгийн эргэлтэд оруулах, махны экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг үндэсний үйлдвэр, төрийн бус байгууллагуудад бодлогын болон эргэлтийн хөрөнгийн зээл олгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, тухай бүр танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгав.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

